

Анги, бүлэг

Шифр

8-Р АНГИЙН ГАЗАРЗҮЙН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

Хугацаа 60 мин

1. Дэлхий дээр 24 цагийн бүсийг ялган үздэг бөгөөд нэг бүсэд өргөөшөө хэдэн градусын нутаг хамрагддаг вэ? /1 оноо/
A. 20 B. 18 C. 22 D. 15
2. Монгол орны хамгийн хүйтэн болдог газар аль нь вэ? /1 оноо/
A. Увс B. Өмнөговь C. Дорнод D. Хэнтий
3. 8 дугаар цагийн бүсэд орших аймгийг сонго. /1 оноо/
A. Дорнод B. Улаанбаатар C. Сэлэнгэ D. Ховд
4. Өмнөговь аймгийн Ханбогд суманд Оюутолгойн стратегийн ач холбогдол бүхий орд газар оршдог. Оюутолгойн ордоос ямар ашигт малтмал олборлодог вэ? /1 оноо/
A. Нүүрс B. Зэс молибден C. Мөнгө D. Уран
5. Хангайн нурууны ноён оргил Отгонтэнгэр уул нь д.т.д 4021 м өндөрт оршдог бол гадаргын ерөнхий хэв шинжийн ангиллын алинд нь хамрагдах вэ? /1 оноо/
A. Өндөр уулс B. Дундаж өндөр C. Говь маягийн уулс D. Цав толгод
6. Агаарын даралтыг ямар багажаар хэмждэг вэ? /1 оноо/
A. Термометр B. Гигрометр C. Барометр D. Курвиметр
7. Агаарын температур, даралт, салхины хурд, чиглэл зэрэг хэмжилтийн үр дүнг боловсруулж зохиосон зургийг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
A. Уур амьсгалын зураг B. Хур тунадасны зураг
C. Цаг агаарын зураг D. Агаарын урсгалын зураг
8. МО-ны хамгийн урт мөсөн гол аль нь вэ? /1 оноо/
A. Үенч B. Потанины мөсөн гол C. Тэс D. Александрын мөсөн гол
9. Голын уналыг тооцоолоход шаардлагатай үзүүлэлтийн нэрийг сонгоно уу? /1 оноо/
A. Голын эх авсан цэгийн өндөр B. Гол дээр сонгож авсан хоёр цэг
C. Голын урт D. Голын өргөн
10. Амьтдыг нэн ховор, ховор, элбэг гэж 3 ангилдаг. Нэн ховор амьтан аль нь вэ? /1 оноо/
A. Мазаалай, тахь адуу B. Цөөвөр чоно, тарвага
C. Монгол бөхөн, цагаан зээр D. Баданга хүдэр, бор гөрөөс
11. Байгалийн бүсүүдээс заг ургадаг бүсийг сонгоно уу? /1 оноо/
A. Тайгын бүс B. Говийн бүс C. Хээрийн бүс D. Ойт хээрийн бүс
12. Зургийг ажиглаад асуултын тэмдгийн оронд тохирох хариуг сонгоно уу/1 оноо/



- A. Тайгын
- B. Хээрийн
- C. Цасны
- D. Цөлийн

13. 19. Иргэн “ Д “ -г Монголын хамгийн сүүлд байгуулагдсан аймагт ажиллахыг санал болгожээ. Энэ ямар аймаг вэ?

- A. Булган B. Завхан C. Говьсүмбэр D. Дорнод

14. Доорх хаяалбар шугамаар дүрслэгдсэн уулын аль хэсэг нь эгц, огтлолын өндөр хэд байна вэ? /2 оноо/



- A. Хойд, 50м
- B. Зүүн, 120м
- C. Өмнөд, 150м
- D. Баруун, 100м


15. Зуны улиралд Монгол орны хойд хагасын нутагт өдрийн үргэлжлэх хугацаа шөнөөсөө арай урт байх ба өвөлдөө эсрэг байдаг. Дараах хотуудын алинд нь зуны улиралд шөнийн үргэлжлэх хугацаа хамгийн бага байх вэ? /2 оноо/

- A. Даланзадгад
- B. Сүхбаатар
- C. Сайншанд
- D. Хөвсгөл

16. Нарнаас ирэх цацрагийн хэмжээ юунаас хамаарч өөрчлөгдөх вэ? /2 оноо/

- A. Уртраг
- B. Өндөр
- C. Голдож
- D. Өргөрөг

17. Өргөрөг ба өдрийн үргэлжлэх хугацааны хамаарлыг харуулсан графикийг ашиглан асуултанд хариулна уу. VI/22-нд Х.Ө 60°-т хэдэн цаг болж байна вэ? /2 оноо/



- A. 12 цаг
- B. 14 цаг
- C. 17 цаг
- D. 19 цаг

18. 5 цагийн хугацаанд дэлхий тэнхлэгээ хэдэн градусгаар эргэх вэ? /2 оноо/

- A. 75°
- B. 15°
- C. 45°
- D. 55°

19. Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээ 1564116 км² ба 2019 онд 3 сая хүн амтай байсан бол хүн амын нягтшилыг олно уу?

- A. 1,7
- B. 0,4
- C. 1,5
- D. 2,0


20. Уулсын оргилыг өндрөөс нь намруу зөв дарааллуулсаныг сонгоорой. /2 оноо/

- 1. Хүйтэн
- 2. Мөнхсарьдаг
- 3. Отгонтэнгэр
- 4. Асралтхайрхан
- A. 1-2-3-4
- B. 1-3-2-4
- C. 1-4-2-3
- D. 1-2-4-3

21. Хүйтэн фронт үүсэхэд цаг агаар ямар шинж чанартай болдог вэ? /2 оноо/

- A. Цаг агаар муудаж, тунадас орно
- B. Цаг агаар дулаарч, тунадас орохгүй
- C. Цаг агаар дулаарч, тунадас орно
- D. Цаг агаар муудаж, тунадас орохгүй

22. Дараах агаарын температурын хувиарлалтын зураг ажиглан хамгийн халуун байх нутгийг сонго. /2 оноо/



- A. Хангайн нуруу
- B. Алтайн өвөр говь
- C. Мэнэнгийн тал
- D. Их нууруудын хотгор

23. Цаг агаар өөрчлөгдөхөд нөлөөлөх хүчин зүйлүүдийг сонгоно уу? /2 оноо/

- A. Агаарын хөдөлгөөн, агаарын температур
- B. Агаарын фронт, агаарын чийгшил
- C. Агаарын масс, агаарын хөдөлгөөн
- D. Агаарын даралт, агаарын температур

24. 3 ай савын хагалбар зааг болдог газар ньболно. /2 оноо/

- A. Цогтчандмань
- B. Хүйтэн
- C. Модон салаа уул
- D. Отгонтэнгэр

25. Номхон далайн ай савд багтах Онон гол дайран урсдаг аймгийг сонгоно уу. /2 оноо/

- A. Булган
- B. Сүхбаатар
- C. Дорноговь
- D. Хэнтий

26. Дараах нууруудыг орших аймагтай нь зөв тохируулсан хариултыг сонгоно уу? /2 оноо/

- 1. Буйр
 - 2. Бөөнцагаан
 - 3. Хар-Ус
 - 4. Хяргас
 - а. Увс
 - б. Дорнод
 - в. Баянхонгор
 - г. Ховд
- A. 1в, 2б, 3а, 4г B. 1а, 2б, 3в, 4г C. 1б, 2в, 3г, 4а D. 1г, 2б, 3а, 4в

27. МО-ны дараах нууруудаас галт уулын гаралтай нуурыг сонго. /2 оноо/

- A. Увс
- B. Уран тогоо
- C. Хөвсгөл
- D. Бөөнцагаан

28. Олон улсын ус, намгархаг газрын сүлжээ буюу Рамсарын конвенцид дараах газруудын аль орсон бэ? /2 оноо/

- A. Хяргас нуур, Даян нуур
- B. Увс нуур, Хар-Ус нуур
- C. Хөвсгөл нуур, Үүрэг нуур
- D. Толбо нуур, Увс нуур

29. Дэлхийн байгаль хамгаалах сангаас нэн тэргүүнд хамгаалах шаардлагатай 200 нутагт манай орноос 2 бүс нутаг бүртгэгдсэн. Дараах зурагт 2-ын тоогоор тэмдэглэсэн газрын нэр юу вэ? /2 оноо/



- A. Говийн их дархан бүс
- B. Хустайн нурууны бүс
- C. Монгол Дагуурын бүс
- D. Увс нуурын ай савын бүс


30. Онон-Балжийн сав газар тусгай хамгаалалттай газар нутгийн аль ангилалд багтах вэ? /2 оноо/

- A. Дархан цаазат газар
- B. Байгалийн цогцолборт газар
- C. Дурсгалт газар
- D. Байгалийн нөөц газар

31. МО-ны нэн ховор амьтан болох баданга хүдэрийн нутагладаг байгалийн бүсийг сонго. /2 оноо/


- A. Мэнэнгийн тал
- B. Хөвсгөлийн уулс
- C. Говь-Алтайн уулс
- D. Өмнийн говь

32. Хөрсний үе давхаргад ургамлын үндэс, хөрсний жижиг амьтад, органик бодисууд хуримтлагдсан байна. /2 оноо/



- A. B үе
- B. A үе
- C. C үе
- D. O үе

33. Дараах зурагт 15-ийн тоогоор ямар боомтыг тэмдэглэсэн байна вэ? /1 оноо/



- A. Замын –Үүд
- B. Эрэнцав
- C. Гашуун сухайт
- D. Ульхан

34. 1:5 000 000 масштабтай газрын зурагт 7 см дүрслэгдсэн голын бодит газар дээрх зайг км-ээр зөв илэрхийлсэн хариултыг сонго. /1 оноо/

- A. 35 км B. 3.5 км C. 350 км D. 75 км


35. Баян-Уул сумын газрын гадаргын ерөнхий онцлогийг зөв тодорхойлсон өгүүлбэрийг сонго. /1 оноо/

- A. Нутаг дэвсгэрийн 6 багтай 4800 гаруй хүн амтай.
 B. Эрээний нурууны салбар уулс, дорнод монголын тал хээрийн бүсийн заагт оршдог
 C. Онон, Улз гол, Гэртийн нуур, Холбоо нуур, Цагаан дэв, Улаалзаргана, Ажнайн рашаан булаг элбэгтэй
 D. Нутгийн хойд хэсэг ойт хээрийн бүсэд үхэр, адуу голчлон өсгөдөг

36. МО-ны уур амьгал бүрэлдэхэд олон хүчин зүйл нөлөөлсөн байдаг. Дараах хүчин зүйлсээс уур амьсгал бүрэлдэхэд хамгийн бага нөлөөлсөн хүчин зүйлийг сонго. /1 оноо/

- A. Гадаргын өндөр B. Далайгаас алслагдсан байдал C. Орших өргөрөг D. Салхины чиглэл

37. МО-ны агаарын температурын хувиарлалтын зураг ажиглан Архангай аймагт жилийн дундаж температур хэд байгааг тооцоол. /1 оноо/



- A. 6-8 хэм
 B. -6 - -4 хэм
 C. 0-2 хэм
 D. 4-6 хэм

38. Дараах гол мөрдийг ай савтай зөв тохируулсан хариултыг сонго. /2 оноо/

1. Орхон, Эг, Идэр а. ТАГУ ай сав
 2. Онон, Хэрлэн, Улз б. Хойд мөсөн далай
 3. Завхан, Тэс, Байдраг в. Номхон далайн

- A. 1б, 2в, 3а B. 1в, 2а, 3б C. 1б, 2а, 3в D. 1а, 2б, 3в

39. Байгалийн бүс ба тариалан эрхлэлтийг зөв харгалзуулсан хувилбарыг сонгоно уу. /2 оноо/

№	Байгалийн бүс	№	Тариалахад тохиромжтой ургамал
1	Ойт хээрийн бүс	а	Хожуу болцтой ургамал, эрдэнэ шиш, усалгаатай тариалан
2	Хээрийн бүс	б	Ургах хугацаа богино, хүнсний ногоо болон хүлэмжийн ногоо
3	Говийн бүс	в	Эрт болцтой таримал хөх тариа
4	Цөлийн бүс	г	Хожуу болцтой таримал үрийн наранцэцэг, шар буурцаг, тарвас

- A. 1б 2в 3г 4а B. 1в 2г 3а 4б C. 1г 2в 3б 4г D. 1б 2а 3г 4в

40. Улаанбаатар хотод 17 цаг болж байхад дараах хотуудад цаг хэд болж байх вэ? /3 оноо/

- A. 2-р цагийн бүсэд орших Москва хот
 B. 8-р цагийн бүсэд орших Сөүл хот
 B. 0 бүсэд орших Лондон хот

41. Цөлжилт үүсгэж буй хүний хүчин зүйлсээс 3-г нэрлэ.

1.
 2.
 3.